2200	Дотоод эх үүсвэрээр	-	-
220001	Барилга байгууламж		
221001	Их засвар		
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
224001	Стратегийн нөөц хөрөнгө		
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
226001	Гадаад эх үүсвэрээр		
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		

232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	868,980,500.00	868,980,500.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
131001	Улсын төсвөөс санхүүжих		
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих		
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	868,980,500.00	868,980,500.00
132001	Орон нутгийн төсвөөс	868,980,500.00	868,980,500.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,800,000.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	62.00
620001	Удирдах ажилтан	15.00	15.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	29.00	31.00
620004	Гэрээт ажилтан	2.00	4.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	58.00	62.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12.00	12.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)		
650003	Ажлын албаны албан хаагч (АА)		
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)		
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)		
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)		
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)		
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	29.00	31.00
650010	Гэрээт ажилтан	2.00	4.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	15.00	15.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,155,786.00	49,309,072.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,105,000.00	49,309,072.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,105,000.00	49,309,072.00
2104	Хангамж, бараа материалын зардал	505,000.00	766,080.00

210401	Бичиг хэрэг	225,000.00	
210402	Тээвэр, шатахуун		766,080.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	280,000.00	
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	48,542,992.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,600,000.00	48,542,992.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,050,786.00	-
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,050,786.00	
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,155,786.00	49,309,072.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,155,786.00	49,309,072.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,155,786.00	49,309,072.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		
131106	Төсвийн урамшуулал		
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03/58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийг удирдлагаар хангах, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэл бүхий орон нутгийн удирдах байгууллага юм.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь төрийн үйлчилгээг ард иргэдэд хүргэх, алагчлалгүй үйлчлэх, эелдэг хамт олонтой болох зорилго тавьж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2020, 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 882.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 17.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13658.8 сая төгрөгөөр буюу 10 дахин нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1.8	1.8
Авлага	2.8	1.3	-1.5
Урьдчилгаа			
Бараа материал	9.8	10.8	1.0
Нөөцийн бараа			
Үндсэн хөрөнгө	1157.9	14815.4	13657.5
Нийт хөрөнгө	1170.5	14829.3	13658.8
Өр төлбөр	9.5	5.6	-3.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1160.9	14823.7	13662.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1170.5	14829.3	13658.8

Мөнгөн хөрөнгө данс оны эцэст төрийн сангийн харилцах дансанд төсөвт төвлөрүүлээгүй үлдээсэн 1.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 1.3 сая төгрөг болж оны эхнээс 1.5 сая төгрөгөөр буурсан нь оны эхний 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст 1.3 сая төгрөгийн авлагатай гарсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.8 сая төгрөг болж оны эхнээс 1.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 36.2 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 35.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл бусад хангамжийн материалын үлдэгдэл 1.1 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13722.5 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 12.8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, бусад эх үүсвэрээр 13742.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсныг бүртгэлд тусгасан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 80 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 13365.4 мянган төгрөгийн хатуу хучилттай замыг бүртгэлд тусгасан байна. Бусад үнэ төлбөргүй авсан 377.3 мянган төгрөгийн хөрөнгө нь барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө байна.

Тайлант онд 33.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан бөгөөд энэхүү акталсан 3 авто тээврийн хэрэгслийн акталсан шийдвэрийг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна. Үүнээс 2 авто тээврийн хэрэгслийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 02 сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсөн, мөн 2021 оны 78 дугаар тогтоолоор 1 авто тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдахыг зөвшөөрсөн тогтоолыг санхүүгийн баримтад хавсаргажээ. Цаашид акталсан хөрөнгийн холбогдох шийдвэрийг санхүүгийн баримтад хавсаргаж байх шаардлагатай байна. Үндсэн хөрөнгөд нийт 97.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өглөг дансны үлдэгдэл 5.6 сая төгрөг болж оны эхнээс 3.9 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцэст тайлант оны үйл ажиллагаатай холбоотой 5.6 сая төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 13662.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 13662.7 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13808.2 сая төгрөгөөр буюу 17.1 дахин өссөн байна. Урсгал санхүүжилтийн орлого өмнөх оноос 88.9 сая төгрөгөөр буюу 11.4 хувиар, үнэ төлбөргүй авсан орлого, хөрөнгийн санхүүжилтийн орлого 13679.7 сая төгрөгөөр буюу 20 дахин өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 117.9 сая төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын анхны төсвийг 741.9 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 868.9 сая төгрөг болгон өөрчилж анх баталсан төсвөөс 127.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 24 арга хэмжээг санхүүжүүлэхээр 868.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 868.9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 867.2 сая төгрөгийг зарцуулж, үндсэн санхүүжилтээс хэмнэгдсэн 1.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэхгүйгээр дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 867.2 сая төгрөг буюу 99.8 хувьтай байна.

Нийт төсвийн 61.4 хувийг цалин, 9.33 хувийг НДШ-ийн зардал, 4.1 хувийг тогтмол зардал, 3.7 хувийг хангамж бараа материалын зардал, 0.15 хувийг норматив зардал, 0.56 хувийг эд хогшил худалдан авах зардал, 0.95 хувийг томилолт, зочны зардал, 0.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 13.5 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 6 хувийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвөөс 49.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авч, тээвэр шатахууны зардалд 0.8 сая төгрөгийг, бараа үйлчилгээний зардалд 48.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Өлгий сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайланд хөрөнгийн тооллоготой холбоотой мэдээллийг үнэн зөвөөр толилуулж, тодруулаагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 867.2 сая төгрөгийн санхүүжилтийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай цалин, НДШ, халаалт зэрэг зардлуудыг хасаж тооцоход тэвчиж болох зардлын дүн 223.7 сая төгрөгийн 10 хувь 22.3 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 2.2 сая төгрөгийн албаны конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, үүнээс үзэхэд Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 102 мэдээллийг хугацаандаа байршуулж, 45 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 118.2 сая төгрөгийн 11 гүйлгээг шилэн дансанд байршуулсан байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын дундаж 68.5% хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ба хариуг ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тооллоготой холбоотой асуудлыг дараагийн аудитаар анхаарах. Төсвийн зарцуулалтыг гүйцэтгэлийн шалгалтаар үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 88.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 2.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 86.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Аудитаар 2.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.Үүнд:

1. Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 868.9 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд төсвөөс зарцуулагдаагүй 1.8 сая төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлээгүй, төрийн сан дахь төсвийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.7-д “энэ хуулийн 43 дугаар зүйлд дааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлээгүй дансны үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Тайлант онд ажилчдад олгосон цалингаас нийт 35.6 сая төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг суутгаж авч, 34.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 0.6 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр харуулж, 0.3 сая төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, санхүүгийн тайланд өглөгөөр харуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.1 “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.3 “бүх өр төлбөр”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлогоос 10 хувиар тооцож албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх”, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6-д “бусдад олгох хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төвлөрүүлээгүй татварыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Аудитаар 86.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөгдлөө.Үүнд:

1.Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд гүйцэтгэлээр 868.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 223.7 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 22.4 сая төгрөгийн урсгал зардлын хэмнэлт гаргахаар тооцож төсөвт төвлөрүүлээгүй, тогтоолын 1.4-т заасныг зөрчиж 2.2 сая төгрөгийн албаны конторын тавилга худалдан авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, Шилэн дансанд тайлант онд нийт 149 мэдээлэл байршуулахаас 45 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3.төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл

үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.3-д “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1-ийн 1.1, 1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

2. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн дүн, санхүүгийн тайлан дахь дүнгээс 22.4 сая төгрөгөөр зөрүүтэй, 10.7 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тооллого хийж баталгаажуулаагүй, Тайлант онд зарцуулсан 20.1 сая төгрөгийн шатахууны нярвын бараа материалын тайланг гаргаагүй, шатахууны орлого, зардлыг 3.2 сая төгрөгөөр дутуу гаргасан, шатахууны зарцуулалтын тооцоо хийгдээгүй, Оны эцэст үйл ажиллагаатай холбоотой 5.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг үүсгэж, шатахууны 0.2 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан, ажиллагсдын цалинг оны эхэнд цалин шинэчлэн тогтоож албажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2-т “хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-т “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 14 дүгээр зүйлийн 14.3.1-д “анхан шатны баримт бүрдүүлэх”, 14.3.2-д “журналд бичих”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Байхгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Өлгий сумын ЗДТГ	4	88.9			2	2.1	2	86.8		